

МОНГОЛ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ СУДАЛСАН СУДАЛГААНЫ ТОЙМ

О.Мягмар

Хураангуй: МУБИС, БНХАУ-ын Хөх хотын Багшийн их сургууль, ОХУ-ын Буриадын их сургууль хооронд 2006 оны хоёрдугаар сард байгуулсан хамтын ажиллагааны гэрээг үндэслэн хэрэгжүүлэхээр тохиролцсон “Монгол хэлтэн хүүхдийн хөгжлийн харьцуулсан судалгаа” төслийн судалгааны ажлыг эхлэхийн тулд юуны өмнө энэ асуудал улс тус бүрийн хэмжээнд хэрхэн судлагдаж ирснийг тоймлон нэгтгэх шаардлага тулгарч байгаа юм. Өөрөөр хэлбэл монгол хүүхдийн хөгжлийн судалгааг өнөөг хүртэл хэрхэн явагдаж ирснийг тоймлон дүн шинжилгээ хийх нь энэхүү төслийн эхлэх цэгийг тодорхойлох чухал ач холбогдолтой гэж үзлээ. МУБИС-ийн судалгааны багийн хамт олон энэхүү зорилгын үүднээс “Бие бялдрын хөгжлийн судалгаа”, “Сэтгэлзүйн чиглэлийн судалгаа”, “Нийгэм-соёлын чиглэлийн судалгаа” гэсэн үндсэн гурван чиглэлээр асуудлын судлагдсан байдлыг тодорхойлохыг хичээлээ. Асуудлын судлагдсан байдлыг ийнхүү хуваасан нь ихээхэн харьцангуй зүйл бөгөөд зөвхөн л техник ажлыг хөнгөвчлөхөд чиглэгдсэнээс болно. Эрэл хайгуулын хүрээнд бид нийт 70 гаруй бүтээлүүдийг тоймлон судаллаа. Эдгээр бүтээлүүд нь судалгааны ажлын тайлан, эрдэмтэдийн диссертаци, ТББ болон бусад байгууллагуудаас хийсэн хялбаршуулсан судалгааны материал, болон статистик мэдээ бусад баримт материал гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэж байгаа юм. Монгол хүүхдийн хөгжлийн онцлогийг судалсан байдлыг тоймлон авч үзсэнээрээ бид энэ хүрээнд судлагдаагүй байгаа асуудлын хүрээг тодорхойлох, өөрсдийн хэрэгжүүлэх гэж байгаа төслийн онцлог ба ялгааг гаргаж тавих, хүрэх үр дүн ба ач холбогдлыг тодорхойлохыг зорьсон болно.

МОНГОЛ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ СУДАЛЖ ИРСЭН СУДАЛГААНЫ ТОВЧ ТОЙМ

Нэг. УБИС-ийн /тэр үеийн нэрээр/ дэргэдэх Сургалтын агуулга-арга зүйн институтийн “Хүүхдийн сэтгэц-физиологийн асуудал судлах хамтлагаас” 1991-1993 онуудад хийсэн “СӨНХ-ийн сэтгэц-физиологийн хөгжлийн зарим асуудлыг судалсан нь” сэдэвт эрдэм шинжилгээний бүтээлийн тухай.

СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:

Хүүхдийн сэтгэц - физиологийн хөгжлийн асуудал судлах хамтлагийн гишүүд: Д.Дашхүү, Д.Энхтуяа, Г.Бадамхатан, Т.Цэндсүрэн, Я.Насандолгор, Ж.Төмөрхуяг.

СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН ХУГАЦАА: 1991-1993

СУДАЛГААГ ХААНААС БАТАЛСАН:

Сургалтын агуулга, арга зүйн институтийн захирал проф. Б.Жадамба баталж, эрдэмтэн нарийн

бичгийн дарга профессор Д.Шагдар зөвшөөрсөн гарын үсэгтэй.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:

“Сургалт, сэтгэцийн хөгжлийн холбоо хамаарал, сургах бодит зүй тогтол, сургуулийн өмнөх насны хүүхдийн, ялангуяа 6 настай хүүхдэд хэрхэн яаж хэрэгждэгийг илрүүлэх нь судалгааны гол зорилт байлаа” гэж бичжээ /Тайлангийн 2-р хуудас/. Цаашдаа хүүхдийг 6 настайгаас нь эхлэн сургуульд хамруулан сургах асуудлын үндсийг хангахад чиглэгдсэн байна.

СУДАЛГААНЫ ХАМТЛАГИЙН АХЛАГЧ: Эрдэм шинжилгээний ажлыг удирдагч, хамтлагийн ахлагч тэр үеийн УБИС-ийн дэргэдэх Биеийн тамирын дээд сургуулийн захирал доктор профессор Га.Цэрэндорж.

СУДАЛГААНЫ АРГА СУДЛАЛЫН ҮНДЭС:

Сэтгэцийн хөгжил тасралтгүй, иж бүрэн шинжтэй нэгдмэл зүйл юм гэсэн үзлийг сургалт ба оюун ухааны хөгжил хоёрын хоорондын холбоо,

хамаарлын тухай Л.С.Выгостскийн онол, Сэтгэц физиологийн үйлийн нарийн зүй тогтлын талаарх И.П.Павлов, П.К.Анохин нарын оросын эрдэмтдийн үзэл бодолд голлон тулгуурласан:

Түлхүүр үгс:

Сургуулийн өмнөх насны хүүхэд, сэтгэц, физиологи, бие бялдар, ерөнхий хөгжил, хөгжлийн хурдац, өнгө ялган таних чадвар, булчингийн хөгжил, хөдөлгөөний эвсэл, хөдөлгөөний дадал, чадвар, хүртэхүй, ой, сэтгэхүй, яриа, арга, арга зүй, судалгаа, туршилт, үр дүн, үзэл баримтлал

Судалгааны түүвэр ба төлөөлөл:

Төслийн хугацаанд говийн бүсээс Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогтцэций, Дорноговь аймгийн Улаан уул, Ренчинлхүмбэ, Өндөр уулын бүсээс Ховд аймгийн Мөнххайрхан, Мөст, Архангай аймгийн Тариат, Хангай Хээрийн бүсээс Дорнод аймгийн Дашбалбар, Баяндун, Төв аймгийн хүүхдийн цэцэрлэгүүд, Улаанбаатар зэрэг газруудаас 3-6 насны хүүхдүүдийг судалгаанд хамарсан. Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 85% нь цэцэрлэг, 15% НТ гэрээр хүмүүжиж байсан. Нийт хүүхдүүдийн 62,3% нь ажилчин, 5,2% нь малчин, 37,5% нь сэхээтний хүүхдүүд байжээ. Судалгаанд халх, буриад, дархад, захчин, урианхай ястны хүүхдүүд хамрагдсан бөгөөд нийт хүүхдийн 52,4% нь охид, 47,6% нь хөвгүүд байсан бөгөөд насны ангиллаар авч үзвэл 3 настай 220, 4 настай 560, 5 настай 570, 6 настай 650 хүүхэд хамрагджээ.

СУДАЛГААНЫ АГУУЛГА:

Судалгааг доорх чиглэлээр хийжээ:

- СӨНХ-ийн физиологи-бие бялдар хөгжлийн судалгаа антропометрийн болон хөдөлгөөний дадлын судалгаа/

- СӨНХ-ийн өнгө ялгах чадвар
- Хүртэхүйн хөгжил
- Ой тогтоолт
- Сэтгэхүй
- Яриа
- Тоглоом

Судалгааны арга зүй:

- Антропометрийн аргууд

- Танин мэдэхүйн процессуудыг судлах тусгай аргууд

- Сургах туршилт

Судалгааны дүгнэлт

Энэхүү судалгааны үндсэн дээр хэд хэдэн чухал дүгнэлт гарснаас заримыг нь дурдвал:

1. Далайн түвшнээс 2400-3000 метрийн өндөрт оршдог Алтайн уулархаг их мужид амьдардаг хүүхдийн өндөр нь далайн түвшнээс 600-1600 метр оршдог Дорнодын тал, Хангай, Хэнтийн их мужийн хүүхдийн Өндөрөөс харьцангуй доогуур байна /121 дүгээр тал/.

2. 3-7 настай хүүхдийн хүртэхүй, ой, анхаарал, сэтгэхүй болон бие бялдар, физиологийн зарим онцлогийг судлан судалгааны материалаа нухацтай боловсруулан, онол практикийн дүгнэлт хийж зөвлөмж боловсруулсан нь манай орны цэцэрлэгийн насны хүүхдийг сургах үйл явцын агуулга арга зүйг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой ажил болжээ /Проф. Д.Санжжавын шүүмжээс/.

3. Алтайн уулархаг мужийн хүүхдийн дүрс таних, өнгө ялгаж нэрлэх чадвар бусад мужид амьдарч байгаа хүүхдээс өндөр байна / 33тал/ г.м.

4. Ерөнхийдөө энэхүү судалгаа нь Монгол улсын хэмжээнд хүүхдийн сэтгэц физиологийн асуудлыг цогц байдлаар нь авч үзсэн анхны судалгаа болсон бөгөөд нарийвчлан үзвэл судалгааны үзүүлэлт, цаашид судлах өгөгдөл ихтэй, нас зүйн үүднээс авч үзвэл сургуулийн бага нас буюу дараагийн насны хүүхдийн судалгааг хийх үндэс болж өгчээ гэж үзэж байна.

5. “СӨНХ-ийн сэтгэц физиологийн зарим онцлогийг судалсан нь” хэмээх судалгааны дүнгээс үзэхэд ийм өргөн цар хүрээтэй судалгааны нэгдсэн дүгнэлт бараг хийгдээгүй, бүлэг сэдвүүдийн үзүүлэлтийг Монгол хүүхдийн хувьд нэгтгэн гаргаж тавиагүй, бие хүний төлөвшлийн асуудлыг хөндөөгүй байгаа нь нэгдүгээрт энэхүү судалгааны материалыг нэгтгэн дүгнэж цаашдын судалгаанд ашиглах, нөгөө талаас судалгааны зорилгын хүрээнд хөндөгдөөгүй асуудлыг нэмж судлах зайлшгүй шаардлага дараа дараагийн судлаачдын өмнө тавигдаж байна.

Хүснэгт 1: “СӨНХ-ийн Сэтгэц физиологийн зарим онцлогийг судалсан нь” судалгааны тухай товч мэдээлэл

Судалгааны нэр	Хаана хийсэн	хугацаа	Түүврийн тоо насны хязгаар	зорилго	Арга зүй	Товч дүн
СӨНХ-ийн сэтгэц-физиологийн хөгжлийн зарим судалгаа	УБИС-ийн харьяа, Сургалтын агуулга арга зүйн Институтийн судлаачдын баг	1990-1993 онуудад хичээлийн жилээр хийгдсэн	4-6 насны 2000 хүүхэд, нийгмийн гарал ба угсаатан ястны төлөөлөл авсан	Сургалт-сэтгэцийн хөгжлийн холбоо хамаарал, сургах зүй тогтлын илрэл, настай хүүхдэд хэрхэн хэрэгждэгийг илрүүлэх	Сэтгэц-физиологийн тусгай арга, аргачлал, төвшин тогтоох судалгаа, сургах туршилт	СӨНХ-ийн сургалтын агуулга, арга зүйг тогтооход чухал үүрэг гүйцэтгэсэн, төсөөлөл, зохион бодохуй, бие хүний төлөвшилийн асуудлаас бусдыг судалсан

Хоёр. “Хүүхдийн оюун ухааны хөгжлийн ерөнхий төвшнийг тодорхойлох сорил” хэмээх судалгааны тухай

Энэхүү судалгааг “Хүүхдийн. Сэтгэцийн хөгжлийн зарим асуудал” сэдэвт төслийн хүрээнд Боловсрол Судлалын Үндэсний хүрээлэнгээс гүйцэтгэжээ.

Судалгааг гүйцэтгэсэн багийн гишүүд:

Д.Дашхүү /ахлагч/
Ж.Батдэлгэр
О.Мягмар
Т.Цэндсүрэн

Судалгааны зорилго:

5-13 настай хүүхдийн оюун ухааны хөгжлийг судлах тест боловсруулан туршилтаар шалгах.

Судалгааны таамаглал:

Хүүхдийн оюун ухааны хөгжлийн төвшинг дундаж, дундажаас дээш, дунджаас доогуур гэсэн гурван ерөнхий төвшинд хуваан авч үзсэний үндсэнд дараах таамаглалыг дэвшүүлжээ: “Сургуулийн өмнөх насанд судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 61-67% нь, сургуулийн бага насанд 68-71%, дунд насанд 75-80% нь дунджаас дээш төвшинд, дээрх үечлэлээр

27-29, 25-27, 18-23% нь дундаж төвшинд, 6-10, 3-5.2% нь тус тус дунджаас доогуур төвшинд байх болов уу?”

Судалгааны түүвэр ба төлөөлөл:

Боловсруулсан тестийнхээ үндсэн загварыг тогтоохын тулд Ховд, Хөвсгөл, Дархан-Уул, Өвөрхангай, Дундговь, Төв аймаг, Улаанбаатар хотын 5-13 насны 270 хүүхдийг судалгаанд хамарсан. Үүнийг насны үечлэлээр авч үзвэл

- Сургуулийн өмнөх
- Сургуулийн бага
- Өсвөр насны эхэн үе байна.

Судалгааны онол арга зүйн үндэслэл:

1. Оюун ухаан бол сэтгэхүйн цэвэр чанарууд амьдралаас тасархай зүйл биш. Энэ хүний идэвхтэй үйл ажиллагаа, амьдрах арга ухаантай холбоотой ерөнхий чадвар юм. Иймээс оюун ухааны хөгжлийн төвшинг оюун ухааны үйлийн агуулга, арга барил, эцсийн үр дүн талаас нь судлах боломжтой.

2. Хүүхдийг амьдрал үйл ажиллагаанд бэлтгэн төлөвшүүлэх, зорилт бүхий өнөөгийн сургалтын агуулга нь хүүхдийн оюун ухааны хөгжлийн гол гол бүрэлдэхүүн хэсгийн ерөнхий мэдлэг, чадвар,

хэл яриа, сэтгэхүй, ой, анхаарал, орон зайн төсөөлөл г.м/ хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлж чадаж байвал сая хүүхдийг хөгжүүлэх үүргээ гүйцэтгэж байна гэж хэлэх үндэстэй.

3. Оюун ухааны хөгжлийн ерөнхий төвшинг иж бүрэн байдлаар тодорхойлохын тулд оюуны гол гол үйлүүдийн /эргэцүүлэн тунгаах, сэтгэмж, сэтгэхүй, сэтгэхүйн хурд, зохион бодохуй, ойд материал хадгалагдах хурд, хугацаа, ухагдахуун төлөвших, шууд мэдрэн таних үйлийн онцлог, анхаарал, орон зайн баримжаалал г.м/ хөгжлийн төвшинг тус тусад нь болон ерөнхийд нь иж бүрэн байдлаар дүгнэж болохуйц агуулгын хувьд өргөн хүрээтэй сорил боловсруулах нь зүйтэй гэж үзсэн.

Тестийг боловсруулахдаа үндэслэл болгосон загвар:

Д. Векслерийн оюун ухааны сорилын хүүхдийн хувилбар буюу WRC-R

Судалгааны агуулга:

Дээрх судлаачдын боловсруулсан тест нь 11 дэд сорилтой. Дэд сорилууд нь үгэн ба үгэн биш гэсэн хоёр үндсэн хэсэгтэй. Үүнд: .

- Энгийн мэдлэг төсөөллийн төвшинг тодорхойлох дэд сорил
- Сэтгэмжийн төвшинг тодорхойлох дэд сорил
- Арифметик үйлдэл хийх чадварыг тодорхойлох дэд сорил
- Ерөнхий шинжийг олох дэд сорил
- Толь бичгээр хийх дэд сорил
- Тоон цувааг сэргээн санах дэд сорил
- Дутуу зүйлийг олж гүйцээх дэд сорил
- Зургийн дарааллаар байгуулах дэд сорил
- Коссын шоогоор хийх дэд сорил
- Өгөгдсөн хэсгүүдээр дүрс бүтээх дэд сорил
- Тоог тэмдгээр илэрхийлэх Дэд сорил

Судалгааны үр дүн:

1. “Сургуулийн өмнөх насны судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 7,1-21,2% нь, сургуулийн бага насны хүүхдийн 30,8-40,6% нь,

дунд насныхны 30,9-46% нь дундаж төвшинд, Дээрх үечлэлээр 45,5-52,6%, 44,1-52,6%, 36,8-60,6% нь дундаж, 30,9-47,3%, 11,5-21,1%, 8,4-17,1% дунджаас доогуур түвшинд тус тус байгаа нь бидний дэвшүүлсэн таамаглалтай зарим талаар тохирч байгаа боловч дээд төвшингийн эзлэх хувь аль ч насанд бага хувийг эзэлж байна...” гэх зэргээр дүгнэжээ. Судалгааны бүх үзүүлэлтийг статистик аргаар боловсруулсныг тус ажлын 11, 12,13 дугаар талуудад тусгажээ

2. Судалгааныхаа дүнг аймгийн төв, сумын төв, хот гэсэн гурван ангилалаар авч үзсэн бөгөөд хот суурин газрын оюун ухааны хөгжлийн үзүүлэлт аймгийн төв ба хөдөөнийхөөс өндөр байна гэж тэмдэглээд үүнийгээ “хот суурин газрын соёл, иргэншил, мэдээллийн нөлөөлөл, багш сурган хүмүүжүүлэгчдийн заах арга барилтай холбоотой” гэж үзсэн байна.

3. Энэхүү судалгааг бүхэлд нь авч үзвэл хүүхдийн оюун ухааны хөгжлийг иж бүрнээр нь судлах, Дэлхийд алдартай Векслерийн тест маягийн тесттэй дүйцэхүйц тестийн монгол хувилбарыг зохион турших гэсэн анхны оролдлого байсныхаа хувьд ихээхэн үнэ цэнэтэй юм. Харин судалгааны дүнгээс үзэхэд тестийг боловсруулах ба түүний адаптацийг хийх асуудал ба хүүхдийн оюун ухааны хөгжлийн төвшинг тодорхойлох судалгаа хоёр нь хоорондоо холилдож тестийн боловсруулсан тестийн мөн чанарын талаарх дүгнэлтийн оронд хүүхдийн оюун ухааны хөгжлийн төвшингийн үзүүлэлттэй холбоотой дүгнэлтийг голлон гаргажээ.

4. Энэхүү судалгааны хүрээнд багийн эрдэмтдийн боловсруулсан асуулга, даалгаврууд нь монгол ахуй ба орчин, монгол хүүхдийн ойлголт төсөөлөлд нэлээд дөхүү болсон учраас цаашид “Монгол маягийн тест” зохиоход санаа авах зүйлүүд багагүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.

*Хүснэгт 2. "Хүүхдийн оюун ухааны хөгжлийн ерөнхий төвшнийг тодорхойлох сорил"
хэмээх судалгааны тухай товч мэдээлэл*

Судалгааны нэр	Хаана хийсэн	Хугацаа	Түүврийн тоо насны хязгаар	зорилго
"Монгол хүүхдийн оюун ухааны хөгжлийн төвшин Тодорхойлох сорил"	Боловсрол судлалын үндэсний хүрээлэн	1996	5-13 насны 270 хүүхэд	5-13 насны хүүхдийн тест боловс-руулан туршилтаар шалгах

Гурав “бага ангийн сурагчдын сэтгэцийн хөгжил төлөвшлийн судалгааны”-ны тухай
Дээр бидний авч үзсэн “СӨНХ-ийн сэтгэц физиологийн зарим онцлогийг судалсан нь” хэмээх судалгааны тайланг уншин дүгнэлт өгсөн эрдэмтдээс доктор профессор Д.Санжжав “Цаашдаа 8-12 насны монгол хүүхдийн сэтгэцийн хөгжлийн судалгааг нэн даруй үргэлжлүүлэн хийх шаардлагатай байна” гэсэн саналыг өгсөн бөгөөд манай эрдэмтэн судлаачид ч ийм цогц судалгааны залгамж холбоог хангахад анхаарч иржээ. Түүний нэг жишээ бол “бага ангийн сурагчдын сэтгэцийн хөгжил төлөвшлийн судалгаа” юм.

Судалгаа хийсэн газар:

Боловсрол Судлалын Үндэсний хүрээлэн
Судалгаа хийсэн багийн гишүүд:

Д.Дашхүү
Б.Чимэдлхам
О.Мягмар
М. Хишиг-Ундрах

Судалгааны арга зүйн үндэслэл:

“Бид ой тогтоолт, сэтгэхүй, үг яриа, харилцаа хандлага, эх мэтээр сэтгэцийн үйл ажиллагааг дан ганц талаас нь судлахыг өрөөсгөл гэж үзээд сэтгэцийн ажиллагаа, бие хүний төлөвшилд иж бүрэн хандахыг хичээж энэхүү судалгааг зохион байгууллаа...”

Судалгааны хэрэглэсэн арга зүйнүүд:

- Сургуульд орох насны болон сургуулийн бага насны хүүхэдтэй ярилцах асуулгууд
- Анхаарлын багц тестүүд
- Ой тогтоолтыг судлах багц тестүүд
- Зохион бодохуйн тестүүд
- Ухагдахуун ба сэтгэхүйн тестүүд
- Бага ангийн сурагчдын сэдлийг

тодорхойлох арга зүйнүүд

- Бие хүний онцлогийг судлах Кеттелийн тест, хүүхдийн хувилбар
- Эцэг эх, багш нартай хийх асуулга, ярилцлагын загварууд г.м

Судалгааны агуулга:

Дээрх арга зүйнүүд нь үндсэндээ судалгаа явуулсан чиглэл ба агуулгаа тодорхойлж байгаа юм. Өөрөөр хэлбэл бага ангийн хүүхдийн танин

Судалгааны дүгнэлт ба үр дүн

1. Хүүхдийн ахуйн мэдлэгийн нөөц орчиндоо баримжаа авах чадвар, хичээл сур хандах хандлага зэрэг нь хэвийн төвшинд байна. Гэтэл тэд овог удам угсаагаа мэдэхгүй байна гэж үзсэн.

2. Сурагчдын ой ба анхаарлын хөгжлийн ерөнхий онцлог, анхаарлын хуваарь тогтворжилт, хараа ба сонсголын онцлог, зохион бодохуй, хүртэхүйн онцлог гэх зэргээр танин мэдэх үйлүүдийг тус төвшинчлөн судлаад зарим онцлог ба төвшинг тоон үзүүлэлтээр илэрхийлж өгсөнд судалгааны ажлын ач холбогдол оршиж байна гэж үзлээ.

3. Мөн энэхүү судалгааны явцад бага ангийн сурагчдын бие хүний төлөв онцлогийг Кеттелийн тестийн хүүхдийн хувилбараар, /хялбаршуулсан/ анх удаа судлах оролдлого хийсэн нь анхаар татаж байна. Өмнөх судалгаануудын явцад энэ чиглэлийн судалгаа хийгдээгүй гэдгийг бид дээр дурдсан билээ. Бага ангийн сурагчдын төлөвшлийг “Зан үйлийн гадагш чиглэсэн хандлага”, “өөртөө итгэлтэй байдал, практик чадвар” гэх зэргээр нийт 11 үзүүлэлтээр гаргасан байна. Жишээ нь нийт судлуулагчдын 50,1%д нь өөртөө итгэлтэй, бие даасан байдлын эерэг ба сөрөг үзүүлэлтүүд

нь 16,72 : 83,28 гэх зэргээр тоон үзүүлэлтүүдээр гаргаж дүгнэлт өгчээ.

4. Судалгааныхаа дүнг нэгтгэн судалгаанд хамрагдсан бага ангийн сурагчдын сэтгэхүйн хөгжлийн төвшин төдий л хангалтгүй, тухайлбал дундаж ба дунджаас Дээш үзүүлэлтийн эзлэх хувь нийлээд 44,98% байна, харин ой тогтоолтын Хөгжлийн төвшний үзүүлэлт 67 4% байгаа нь тэдний сургалт ой тогтоолтод тулгуурлаж байна гэсэн сонирхолтой дүгнэлтийг хийжээ.

Хүснэгт 3. "Бага ангийн сурагчдын сэтгэцийн хөгжил, төлөвшлийн судалгаа"-ны товч

Судалгааны нэр	Хаана хийсэн	хугацаа	Түүврийн тоо, насны хязгаар	Зорилго
Бага ангийн хүүхдийн сэтгэцийн төлөвшлийн судалгаа	БСҮХ	2000-2002	311	Бага ангийн сурагчдын танин мэдэх үйл ба бие хүний төлөвшлийг судлах

Дөрөв. Сэтгэлзүй - сурган хүмүүжүүлэх ухааны чиглэлээр хийгдсэн бусад судалгаанууд

Монгол хүүхдийн танин мэдэхүйн зарим тодорхой үйлүүд болон нийгэм сэтгэл зүйн онцлогийг судлахад чиглэсэн магистр ба докторын ажлууд цөөнгүй байгаагаас бид энэ удаа заримыг нь тоймлог авч үзлээ. Зарим судалгааны нэр, түүвэр ба арга зүйг доорх хүснэгтээр харуулав. Үүнд:

Хүснэгт 4. Эрдэмтдийн судалгааны ажлын тойм

Судалгааны нэр	Хийсэн хүний нэр	Хийгдсэн он ба түүвэр	Арга зүй	Гол үр дүн
5-8 дугаар ангийн сурагчдын анхаарлын тогтворжилтын насны онцлог	П.Цэрэндондов (Ph-ажил)	1992 он 3369 сурагч	Бурдоны тест	Монгол сурагчдын анхаарлын тогтворжилтын хөгжлийн динамик, зарим хүчин зүйлийг илрүүлсэн
8-10 настай Монгол С.Оюунгэрэл хүүхдийн анхаарлын чанаруудыг судалсан нь	магистрын ажил) С.Оюунгэрэл	1997 он 8-10 насны 818 сурагч	Тахистакопын Ландольтын цагираг анхаарлын төвлөрөлт шалгах сэдэвт зураг, Шульцийн тоон тест	8-10 настай Монгол хүүхдийн анхаарлын чанаруудыг иж бүрнээр судалсан нь
Орос монголын ахлах сурагчдын нүүрний хувирлын танин онцлог	(Ph -ажил) Д.Дэлгэрмаа	2002 он, 596, үүнээс орос 298, монгол Ю.А.Менд-	В.А.Лабунская, Ю.А.Менджерицкая А.Кориник нарын нийгмийн перцепцийг судлах арга зүйнүүд	16-18 насны монгол ба орос сурагчдын хүний нүүрний хувирлыг таних үндэстний онцлогийг хэд хэдэн хүчин зүйл, үзүүлэлтээр авч үзсэн

		жерицкая, 298		
5-7 настай хүүхдийн оюун ухаан ба нийгэмшлийн хамаарлын судалгаа	Т.Цэндсүрэн (Ph -ажил)	1994 он 300 хүүхэд	Векслерийн тест нийгэмшлийн үзүүлэлт боловсруулах, ажиглах, турших-сургалт	Тусгай хэрэгцээт хүүхдийг эрүүл хүүхдүүдтэй интеграцилан сургах боломжтой, хүүхдийн сайн тал дээр түшиглэх нь зүйтэй гэж үзсэн.
Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн хөгжлийг судалсан нь	Ц.Баттуяа (Ph -ажил)	2003 он 380 хүүхэд	Тест Асуулга-туршилт	Тоглох үйл ажиллагаа болон орчныг зөв зохион байгуулснаар энэ насны хүүхдийн нийгэмшлийг хөгжүүлнэ.
Хүүхдийн богино хугацааны ойг судалсан нь	М.Хишиг-Ундрах (Ph -ажил)	2005 оны 8-11 нас 410 хүүхэд	Эббингауз, Джобс, А.Н.Леонтьев нарын богино хугацааны ойг судлах арга зүй	Когнитив онолуудын харьцуулалт хийгдсэн, богино хугацааны ойг хот хөдөөгөөр харьцуулсан

Тав. Монгол хүүхдийн бие, бялдрын хөгжлийн талаар хийгдсэн судалгааны тойм

Хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилт, эрүүл мэндийн байдал, бэлтгэлжилтийн түвшнийг нас, хүйс, улс орны нийгэм-эдийн засгийн байдалтай уялдуулан 5-10 жил дутам судлах, тухайн газар нутаг, улс орны уугуул хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилтийн жишгийг тогтоодог шинжлэх ухааны зайлшгүй шаардлагын дагуу монголын анагаах ухаан ба биеийн тамир спортын салбарын эрдэмтэд цөөнгүй судалгаа хийжээ. Эдгээр судалгааны ажлуудад бие бялдрын өсөлт, хөгжлийн байдал, бэлтгэлжилтийн түвшинд үнэлгээ өгөхдөө антропометрийн хэмжилт хийх, /ЗСС, амьсгал/ эрхтэн тогтолцооны физиологийн үйл ажиллагааны хэвийн үзүүлэлтүүдийг нь тодорхойлох хөдөлгөөний, /биеийн/ чанаруудыг үнэлэх өвөрмөц аргуудыг өргөн ашигласан байна.

Ч.Цолмон (1994) 16 настай хөвгүүд 1961 оныхоос 9,6 см-ээр, 1973 оныхоос 6,0 см – ээр тус тус өссөн болохыг тогтоожээ.

Анагаах ухааны салбарын судалгаануудаас Ч.Чүлтэмдорж (1960) онд 0-16 насныхны бие бялдрын өсөлт, хөгжилтийн үзүүлэлтүүдийг судалж идэвхтэй өсөлтийн нас нь хөвгүүдэд 14-

15, охидод 14-15, биеийн жингийн хамгийн их өсөлт нь хөвгүүдэд 14-15 нас, охидод 12-13 насанд байгааг тодорхойлжээ.

Д.Батчулуун (1981) 0-17 насны хүүхдүүдийн өсөлтийг тогтоож үндсэн үзүүлэлтүүдийг гаргажээ. Судалгааныхаа үр дүнд “Акселераци явагдаж хүүхдийн өндөр 4 см-ээр, жин 1 кг-аар, цээжний тойрог 2 см-ээр нэмэгдэж бэлгийн бойжилт 2 насаар урагшилсан” хэмээн дүгнэжээ.

Дүгнэлт санал

Би Монгол улсын хэмжээнд монгол хүүхдийн бие бялдар, сэтгэц, физиологийн онцлогийг өнөөг хүртэл судалж ирсэн судалгаануудыг тоймлон авч үзээд доорх дүгнэлтийг байна.

1. Бид энэ удаа сэтгэл судлалын чиглэлээр хийгдсэн иж бүрэн судалгааны тайлан гурвыг, төрийн бус байгууллагаас хийсэн хялбаршуулсан судалгааны тайлан хоёрыг тус тус, шинжлэх ухааны докторын нэгийг, (Ph.D) Докторын ажил 10 гаруй магистрын ажил 20 орчмыг авч үзсэн бөгөөд сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлалын чиглэлийн нийт 30 гаруй бүтээлтэй танилцлаа. Эдгээрээс томоохон цар хүрээ бүхий зарим ажлаас дурдвал: 1990-1993

Судалгааны нэр	Хийсэн хүний нэр	Хийгдсэн он ба түүвэр	Арга зүй	Гол үр дүн
Монгол хүүхдийн бие бялдрын хүмүүжлийн онол, арга зүйн зарим үзүүлэлтүүд	Га.Цэрэндорж (Sc.D -ажил)	1996 он, 3-17 насны 100.000	Төрөл бүрийнх зайны гүйлт, урт ба өндрийн харайлт, бөмбөг түлхэлт, гранат шидэлт, динаметрээр булчингийн хүч үзэх	Бие бялдрын хөгжлийн үзүүлэлтүүдийг нас насаар нь гаргаж Япон, Хятад, Өвөр Монголын хүүхдүүдтэй харьцуулсан
ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийн байдлыг судалсан нь	Л.Уртнасан	9-10 дугаар ангийн 1840 сурагч	30 м-ийн гүйлт байрнаас уртад суугаа байдлаас урагш 6 минутын гүйлт суугаа байдлаас бөмбөг шидэх, суниалт хийлгэх	Сургуулийн ахлах насныхны хурд, хүчний чадвар, тэсвэрийн чанар, өндөр, уян хатан чанар зэргийг түвшинчлэн тогтоох дүгнэлт хийсэн.
Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорил	Засгийн газрын тогтоолын дагуу өрхийн эмнэлгүүдийн хүрээнд хийгдсэн	11-18 насны 309995 түвшин тогтоох сорил суралцагч хамрагдсан	Антропометрийн аргууд	Өндөр үзүүлэлтүүд гарсныг дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас эргэж харах шаардлагатай гэж эргэлзсэн үнэлгээ өгчээ

онуудад УБИС-ийн /хуучин нэрээр/ сургалтын агуулга арга зүйн институтээс хийгдсэн 4-6 насны 2000 хүүхдийг хамруулсан “СӨНХ-ийн сэтгэц физиологийн зарим онцлогийг судалсан нь сэдэвт судалгаа”, 1996 онд БСҮХ-ээс 5-13 насны 300 орчим хүүхдийг хамруулан явуулсан “Монгол хүүхдийн оюун ухааны хөгжлийн төвшин тодорхойлох сорил” судалгаа, мөн БССҮХ-ээс хийгдсэн 270 хүүхдийг хамарсан “Бага ангийн сурагчдын сэтгэцийн хөгжил төлөвшлийн судалгаа” шинжлэх ухааны доктор, профессор, Д.Санжжавын дунд сургуулийн 5-8р ангийн монгол хүүхдийн бие даасан чанарыг хөгжүүлэх сэтгэл зүйн үндэс “Монгол хүүхдийн оюун ухааны хөгжлийг сургалтын агуулгын өөрчлөлттэй уялдуулан судалсан нь” сэдэвт судалгаа, философийн доктор П.Цэрэндондов, Ж.Батдэлгэр, магистрант С.Оюунгэрэл, Б.Туяа нарын олон судалгааг нэрлэж болох юм. Энэ бүгдээс үзвэл манай оронд Монгол хүүхдийн сэтгэц физиологийн онцлогийг судлах судалгааны зохих туршлага чиглэлийн нэлээд

үнэтэй, цэнэтэй материал хуримтлагдан бий болжээ. Иймээс бид урьд өмнө хийгдсэн эдгээр судалгааг өргөн цар хүрээтэйгээр тоймлон авч үзсэн бөгөөд үүнийгээ шинээр боловсруулах төслийнхөө эхлэл гэж үзэж байна.

2. Судалгааны агуулгыг ерөнхийд нь авч үзвэл Монгол хүүхдийн сэтгэц физиологийн онцлогийг судлах судалгаа нь хэд хэдэн онцлогтойгоор хийгдэж иржээ. Нэгдүгээрт, монгол хүүхдийн сэтгэцийн хөгжлийг СӨНХ-өөс эхлэн эрэмбэ дараалалтай судлах бодлогыг 1990-ээд оноос хойш эрчимтэй баримталж ирсэн, боловч ихэнх судалгаа СӨНХ дээр төвлөрсөн. Хоёрдугаарт, сургуулийн бага ба өсвөр насныхны сэтгэцийн хөгжлийг судлах оролдлогууд аль хэдийн эхэлсэн бөгөөд СӨНХ-ийн судалгааг цаашид үргэлжлүүлэн залгамжлуулах чиглэлийг баримталсан байна. Ингэхдээ ой, анхаарал, сэтгэхүй зэрэг танин мэдэхүйн хүрээний судалгаа зонхилсон бөгөөд судалгааг сургалтын үйл явц, агуулгатай

холбохыг хичээжээ. Эрдэмтдийн эрдэм судлалын ажлын хүрээнд хийгдсэн судалгаануудыг авч үзвэл анхаарлаас бусад танин мэдэхүйн үйлүүдийн судалгааны залгамж холбоо төдий л гараагүй байна. Доктор П.Цэрэндондов, магистр С.Оюунгэрэл нарын судалгаа сургуулийн бага ба өсвөр насны хүүхдүүдийн анхаарлын чанаруудын онцлогийг нэлээд залгамж холбоотой тусгасан ажлууд болжээ. Бусад эрдэмтдийн хувьд ихэвчлэн танин мэдэх үйл явцын шинж чанар, онцлогийг судлахад чиглэсэн нэлээд нарийн асуудлуудыг хөндсөн бөгөөд хувь хүмүүсийн хийсэн судалгаа учраас эдгээрийн хооронд төдий л нарийн залгамж холбоо харагдахгүй байгаа нь ч зүйн хэрэг юм.

3. Судалгааны агуулгатай холбоотойгоор анхаарал татаж байгаа өөр нэг асуудал бол монгол хүүхдийн бие хүний хөгжил төлөвшлийн болон нийгэм – соёлын хүрээний асуудал юм. Энэ чиглэлийн судалгааг төдийлөн дорвитой хийгдээгүй бөгөөд бие хүний онцлогийг судлах Кеттелийн тестийн хүүхдийн хувилбарыг хялбаршуулсан байдлаар 2000 онд БСҮХ-ээс Дэд профессор Д.Дашхүүгийн удирдлагаар хийгдсэн судалгаанаас өөр дорвитой зүйл алга гэж үзлээ. Иймээс монгол хүүхдийн бие хүний төлөвшил болон нийгэм — сэтгэл зүй, иргэншлийн онцлогийг судлах талаар шинээр эхлэх төслийн хүрээнд онцгой анхаарах шаардлагатай байгаа нь харагдлаа.

4. Судалгааны арга зүйн хувьд дээрх судалгаануудыг авч үзвэл танин мэдэх үйлийн судалгааны аргууд нь ихэвчлэн сэтгэл судлалын шинжлэх ухаанд тодорхой хэрэглэгддэг аргуудыг хэрэглэсэн ба бусад хүрээний судалгаанууд нь хялбаршуулсан арга зүйнүүдээр хийгджээ. Манай улсад сэтгэл зүйн судалгааны тестийн адаптацийн асуудал зөвхөн

эхлэл шатандаа явагдаж байгаа билээ. Тодруулбал, МУБИС-ийн судлаач багш Б.Туяа оюун ухааны хөгжлийг тодорхойлох Амтхауэрийн сорилын адаптацийг шинжлэх ухааны шаардлагын дагуу хийж энэхүү судалгааны ажлаа дуусгаад байгаагаас өөр энэ талын мэдээлэл алга байна. Иймд одоо эхлэх гэж байгаа төслийн судалгааны хүрээнд судалгаа авах арга зүй ба тестүүдийн найдварт болон баталгаат чанар, адаптацийн асуудлыг онцгой анхаарах хэрэгтэй юм.

5. Монгол хүүхдийн бие бялдрын хөгжлийн судалгааг 20 орчим судалгааны ажил, зохиол бүтээлийн хүрээнд тоймлон үзлээ. 1960-аад оноос хойш энэ чиглэлийн судалгаа нэлээд өргөн цар хүрээтэй хийгдэж иржээ. Үүнд 100 гаруй мянган хүүхдийг хамарсан доктор (Sc. D), профессор асан Га.Цэрэндоржийн судалгаа, доктор (Ph.D) Л.Уртнасангийн судалгаа болон бусад судалгааг дурдаж болох юм. Эдгээр судалгаануудын үндсэн дээр монгол хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилт, бэлтгэлжилтийн байдлыг харуулах үндсэн үзүүлэлтийг гаргасан.

Санал:

1. “Монгол үндэстэн хүүхдүүдийн сэтгэцийн хөгжлийн судлагдсан байдал ба цаашдын зорилт” гэсэн сэдвээр гурван улсын хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах.
2. “Судалгааны найдвартай гарах үндсэн нөхцөл мөн” гэсэн үзлийг эш үндэс болгон төслийн хүрээнд авах судалгааны арга зүйнүүдийг боловсруулан адаптаци хийхэд эн тэргүүнд анхаарах.
3. Төслийн судалгааг эхлэхэд зайлшгүй чухлаар тавигдах энэхүү хоёр асуудлаар гурван улсын уулзалтыг төслийн эхний шатанд зохион байгуулах.